



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ У.БОЛДХҮҮ

## АГУУЛГА

Нэг.Зорилт .....	3
Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/ .....	3
Гурав. Бүртгэлийн үйл ажиллагаа .....	7
3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд : .....	7
3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд: .....	9
3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд: .....	12
3.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа .....	15
3.5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн талаар .....	16
Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд.....	21
Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа .....	22
Зургаа. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт .....	23
Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Байгууллагын цахим хуудас, санхүүгийн үйл ажиллагаа / .....	24
Найм. Сургалтын төлөвлөгөөг тайлагнах ажлын хүрээнд .....	26
Ес. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/ .....	28
Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил.....	33

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Нэг.Зорилт

Тус хэлтэс нь 2024 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Алсын хараа-2050" Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Хэлтсийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, УИХ-ын болон АНСДИТХ-ын ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж ажиллах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат, дамжлагыг багасгах зорилт тавьж нэг цонхны үйлчилгээний танхимд 24/7 ДӨТ машиныг байршуулан ажилласан болно.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ зүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

#### **Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/**

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг аймгийн нийт иргэн, хуулийн этгээдэд хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн

- 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн №1
- 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн №2
- 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн №3
- 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн №4
- 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн №5
- 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн №6
- 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн №7
- 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн №8
- 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн №9
- 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн №10
- 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн №11
- 2024 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн №13
- 2024 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн №14
- 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн №15
- 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн №16
- 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн №17
- 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №18
- 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн №19
- 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн №20 үүрэг даалгаврын

биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

## **Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар**

Иргэний улсын бүртгэлийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн 03/188 тоот албан бичгээр 100 ба түүнээс дээш настануудын судалгааг гаргаж Отгон ахлахд телеграммаар хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 3/12305 тоот албан бичгээр ирүүлсэн улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар бүртгэлтэй жагсаалтыг шэйр 100 цахим хуудаснаас 26-ны өдөр татан авч шалган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Манай аймгийн нас баралтын бүртгэл давхар бүртгэгдсэн 195 иргэн байгаар төвийн 3 улсын бүртгэгч, архивч нараар архивын эх нотлох баримттай тулгалт хийлгэн шалгуулав. Эх нотлох баримт нь гарсан 95 иргэн буюу 191 бүртгэлийг жагсаалт үйлдэн хэлтсийн Хяналтын улсын байцаагчид хүлээлгэн өгч 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 117 тоот дүгнэлт гаргуулан газарт хүргүүлэн ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 1/655 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг чиглэл хүргүүлэх тухай чиглэлийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр хэлтсийн нийт албан хаагч нарыг оролцуулсан өргөтгөсөн хурал зохион байгуулж улсын бүртгэлийн хөтлөх үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдалыг давтан гаргахгүй байхыг анхааруулав.

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, анхааруулга болон үүрэг даалгаврыг тухай бүрт нь улсын бүртгэгч нарт хүргүүлэн хэлтсийн дарга болон хяналтын байцаагчийн хамт онлайн хурлыг 7 хоног болгон зохион байгуулан холбогдох хууль журмын хүрээнд ажиллан өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хийж гүйцэтгэх, иргэдэд ямар нэгэн хүнд суртал гаргаалгүй ажиллахыг тогтмол үүрэг болгон ажиллаж байна.

Иргэний бүртгэлийн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 3/1100 тоот албан бичгийн дагуу ирүүлсэн чиглэлийг улсын бүртгэгч нарт тухай бүрт хүргүүлэн төлбөр тооцоог чиглэлд заасаны дагуу авч байхыг анхааруулж үйлчилгээний үнэ хураамжийг Гэрэгэ киоскоор төлсөн тохиолдолд тухай бүр баталгаажуулж байхыг үүрэг болгосон. Хэрвээ тухай бүр баталгаажуулан ажиллахгүй эерчил гарсан тохиолдолд улсын бүртгэгч өөрөө хариуцан төлбөрийг барагдуулан гэдгийг анхааруулсан болно.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 3/1171 дугаартай албан бичгийн дагуу ирүүлсэн Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн нэг хаягт эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр ижил гэх нийт 3 иргэний холбогдох бүртгэлийг архивын эх нотлох баримтыг хянан шалгаж, иргэдэд мэдэгдэж улсын бүртгэлийн хууль журмын дагуу хавсралтанд дурдсан нэр бүхий 3 иргэний давхар регистрийн дугаар, давхар төрсний бүртгэлийг хүчингүй болгуулахаар Хяналтын улсын байцаагчид шилжүүлж дүгнэлт гаргуулсан.

Улсын бүртгэгч С.Гүлжан нь архивын эх нотлох баримтыг цахим санд цахимжуулан Хяналтын улсын байцаагчийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 407 дугаартай дүгнэлтийг хавсралтын хамт Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан.

2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр ИУБГ-аас онлайн сургалт зохион байгуулав. Үг сургалтаар сумдыг хариуцан ажиллах улсын бүртгэгч нарын хуваарыг

гаргаж ирүүлэх мөн улсын бүртгэгч нарын сургалтыг зохион байгуулан илтгэх хуудсаар хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 3/10321 тоот чиглэлийн дагуу Иргэний бүртгэлийн тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журмыг үндэслэн хурууны хээгээр бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа жагсаалтыг 7 хоногийн пүрэв гаригт тогтмол ИУБГ-т хүргүүлэн ажиллаж байна.

2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 3/12816 тоот албан бичгээр ирүүлсэн ИУБГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.7-д "иргэний улсын бүртгэлийн нэмэлт, өөрчлөлт, нөхөн бүртгэлд бүртгэсэн бүртгэлийг шалгах" ажил тусгагдсаны дагуу аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст 2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс 08 дугаар сарын 16-ны өдөр хүртэл бүртгэгдсэн бүртгэлд шалгахад илэрсэн алдаа зөрчлийг улсын ахлах бүртгэгч нарт цахимаар хүргүүлсэн. Уг ажлын хүрээнд улсын ахлах бүртгэгч мийн бие ИУБГ-т 3 хоног ажиллан нэмэлт өөрчлөлтийн болон нөхөн бүртгэлийн бүртгэлийг тухай бүр шалгаж илэрсэн зөрчлийг иргэний бүртгэлийн газрын бүртгэгч нартай хамт засаж залруулан зөрчлийг арилган ажилласан болно.


2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 3/13051 тоот албан бичгээр ирүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/671 тушаалаар байгуулагдсан "Мэдээллийн сан цэгцлэх" ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 2 буюу түүнээс дээш бүртгэгдсэн төрсний, нас барсны бүртгэлийн аль нэг бүртгэлийг хүчингүй болгоход 16 иргэний төрсний бүртгэл, 1 иргэний нас барсны бүртгэл нийт 17 бүртгэлийг жагсаалтаар хүлээн авч цахим мэдээллийн сан болон архивын эх нотлох баримт бичигтэй тулган шалгаж хэлтсийн хяналтын улсын байцаагчид шилжүүлэн 4492, 4556 тоот дугаартай дүгнэлтүүдийг гаргуулж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн мэдээллийн санг зөвтүүлэн ажилласан болно.

УБЕГ-ын шуурхай хурал болон ИУБГ-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр гүйцэтгэн илтгэх хуудсаар хүргүүлэн ажиллаж байна.

#### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар**

Өнөөдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх, гэрээ хэлцлийг 3 хоногийн дотор, барьцааны гэрээг ажлын 8 цагийн дотор тус тус бүртгэж, улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баян-Өлгий аймгийн хэмжээнд Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Улаанхус, Бугат, Буянт, Сагсай, Толбо, Цагааннуур сум зэрэг 8 сумаас үзүүлж байсан ба "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд дээрх 8 сумдаас хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Ингэснээр төвлөрлийг сааруулах, бүртгэлийн үйлчилгээг анхан шатанд шилжүүлэх ажил амжилттай хэрэгжиж байна.




Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн тоо /сумаас/

- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2023 оны 12-р сарын 28-ны өдрийн 5/12510 тоот дугаартай чиглэл
- ХШГазраас ирүүлсэн 2024 оны 01-р сарын 08-ны өдрийн 6/208 тоот чиглэл
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 01-р сарын 09-ны өдрийн 5/281 тоот дугаартай чиглэл
- УБЕГазраас ирүүлсэн 2024 оны 01-р сарын 17-ны өдрийн 1/655 тоот дугаартай үүрэг, чиглэл
- УБЕГазраас ирүүлсэн 2024 оны 03-р сарын 04-ны өдрийн 2/2820 тоот дугаартай чиглэл
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 03-р сарын 01-ны өдрийн 5/2717 тоот дугаартай чиглэл
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 04-р сарын 03-ны өдрийн 5/4259 тоот дугаартай хэлэлцүүлэгт оролцох тухай
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 03-р сарын 25-ны өдрийн 5/3783 тоот дугаартай чиглэл
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 04-р сарын 12-ны өдрийн 5/4803 тоот дугаартай чиглэл
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 05-р сарын 08-ны өдрийн 5/6203 тоот дугаартай чиглэл
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 2024 оны 05-р сарын 15-ны өдрийн 5/6579 тоот дугаартай чиглэл
- УБЕГазраас ирүүлсэн 2024 оны 07-р сарын 30-ны өдрийн 2/9609 тоот дугаартай чиглэлүүдийг тухай бүр хурал хийж танилцуулан, хэрэгжилтийг хангаж мөрдөж ажиллаж байна.



Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /ergz/ цахим системд ажиллах, бүртгэл хөтлөх талаар zoom-р арга зүйн сургалт зохион байгуулсан. Бүртгэлийн эх нотлох баримтыг бүрэн гүйцэт авах, эх нотлох баримтыг баталгаат шудангаар хугацаанд нь хэлтсийн архивт хүргүүлж байгаа эсэхт улсын ахлах бүртгэгч тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



Хүснэгт 1. 2024 онд төсөвт оруулсан орлого

## Гурав. Бүртгэлийн үйл ажиллагаа

### 3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :


Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан "Иргэний улсын бүртгэл хөтлөх журам"-уудыг мөрдлөг болгон Иргэний

улсын бүртгэлд 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 31,456 иргэн хамрагдсанаас:

Төрсний бүртгэл 2336, хүүхэд үрчлүүлсний 91, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 62, эцэг, /эх/ тогтоосны 13, гэрлэсний 554, гэрлэлт дуусгавар болсны 50, нас барсны 539, иргэний үнэмлэх олголтын 4599, үндэсний энгийн гадаад паспорт 9207, хил нэвтрэх үнэмлэх, түүнийг орлох бичиг баримтийн олголт 10, биеийн давхцахгүй өгөгдлийн 3929, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 2693, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нөхөн бүртгэлд 220 иргэн тус тус бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 5769 лавлагаа олгосон ба иргэнд 4410 лавлагаа, албан хэрэгцээнд 383 лавлагаа, хууль хяналтын болон төрийн байгуулагаад албан тоотоор 965 лавлагааг тус тус олгосон болно. Тайлант хугацаанд 19444 бүртгэлийн 39526 хуудас материалыг цахимжуулсан. /хүснэгт 2/


Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтэсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор төрөлтийн 365, гэрлэлтийн 35, нийт 400 иргэнд гэрчилгээ олгов.



Хүснэгт 2. Иргэний улсын бүртгэлийн тоон мэдээ


16 иргэний регистрийн дугаарыг Шүүхийн шийдвэр болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр нас тогтоолгосон болон Регистрийн дугаар өөрчилсний бүртгэлд бүртгэж, регистрийн дугаарыг өөрчилж Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр хугацаанд хүргүүлж ажиллав. Шүүхийн шийдвэр болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн биелэлтийг тухай бүр Хяналтын улсын байцаагчид хянуулж ажилласан болно. Үүнд: Шүүхийн шийдвэрээр регистрийн дугаар өөрчилсний бүртгэл 1, Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр регистрийн дугаар өөрчилсний бүртгэл 15 байна. Эзэгтэй 11, Эмэгтэй 5.





Шүүхийн шийдвэртэй үрчлэлт хүчингүй болсон 22 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд бүртгэл хөтлөж УБЕГ-т хүргүүлж хууль журмын иргэний цахим мэдээллийн санд үрчлэлтийн бүртгэлийг хүчингүй болгосон.

Гадаадын иргэн, Харьяалалгүй хүний иргэний улсын бүртгэлийн чиглэлээр гэр бүлийн байдлын бүртгэлээс нийт 25 бүртгэлд иргэний өргөдлийг хүлээн авч хуулийн дагуу бүртгэсэн. Үүнээс: Гадаадын иргэн, Харьяалалгүй иргэний төрсний бүртгэл 15, үрчилсний бүртгэл 1, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 3, гэрлэсний бүртгэл 4, гэрлэлт дуусгавар 1, нас барсны бүртгэл 1 бүртгэж бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулан улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон болно.




Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт нийт 768 иргэний мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас шалгаад архивын эх нотлох баримтыг үндэслэн Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд холбогдох бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай жагсаалт гаргаж шийдвэрлэж байв. 768 иргэний ХААТР маягуудыг нэг бүрчлэн цахим архивт үнэн зөв цахимжуулж оруулсан болно. Мөн үндэс угсаа зөрүүтэй нийт 525 иргэний мэдээллийг засуулж оруулсан байна. Мөн УБЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр давхар бүртгэгдсэн нас барсны бүртгэлтэй 195 иргэний мэдээллийг шалгаж 98 иргэнд, төрсний бүртгэлийн 16 иргэнд дүгнэлт гаргуулж давхар бүртгэлийг хүчингүй болгуулсан байна.

### **3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2024 оны байдлаар дараах бүртгэлүүдийг хийж гүйцэтгэв. Үүнд:

Тайлангийн хугацаанд үйлчилгээний хураамжийн орлого 261.429.119 төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдсанаас оруулсан татварын орлого

892.631.587 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 73.523.096 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна.




Хүснэгт 3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Нийтдээ 10701 мэдүүлэг, онлайн 81 мэдүүлэг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэснээс буцаасан мэдүүлэг 116, газар өмчлөх эрхийн бүртгэл 229, газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл 1937, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 586 шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 101 тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.

Тайлангийн хугацаанд нийтдээ 1431 өмчлөх эрх шилжих гэрээ бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 1005, бэлэглэх гэрээ 165, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 160, шүүхийн шийдвэрээр 8, арилжих гэрээ 6, албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх 2, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 81 бүртгэл бүртгэж баталгаажуулсан байна.

Арилжааны банкуудаар дамжуулан олгосон нийтдээ 7049 барьцааны гэрээ бүртгэсэн ба барьцаалбартай барьцааны гэрээ 1402, барьцаалбаргүй барьцааны гэрээ 1743 барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 141, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 359, барьцааны гэрээ дуусгавар болгох 3403, МИК-аас барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл онлайнгаар 81, бүртгэж баталгаажуулсан байна. Өмнөх үетэй харьцуулахад барьцааны гэрээний бүртгэл 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Тайлангийн хугацаанд 906 бүртгэлд өөрчлөлт оруулсан бөгөөд үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгох 11, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх 13, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх 19, гэмтэсэн гэрчилгээ шинээр олгох

3, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 9, эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх 257, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 592 тус тус бүртгэж баталгаажуулсан байна.

Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 228 лавлагаа, 84 хуулбар олгож, 194 хувийн хэргийг хаасан байна. Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичигт эрх түдгэлзүүлсэн 106, эрх сэргээсэн 79 үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг цахим санд тусгасан байна. Мөн хөрөнгийн багцад тусгай тэмдэглэл 60 хийв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс хаягийн зөрүүтэй 4 иргэний мэдээллийн зөрчилтийг арилгаж шийдвэрлэв.

Иргэд хоорондоо худалдах, худалдан авах гэрээ хийсэн боловч өөрийн нэр шилжүүлэх бүртгэл хийлгээгүй 2, аль дээр оны өмнө байшингаа нураасан боловч эрхийн улсын бүртгэлээ хаалгаагүй 3 иргэний бүртгэлийг газар дээр нь шуурхай шийдвэрлэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг шалгуулахаар ирсэн иргэдийн хүсэлтийг ерс системээс тухай бүр шалгаж мэдээллээр ханган зөвлөн тусалж ажиллав.



Хэлтсийн нэгжийн зохион байгуулалатаар төвийн 4 улсын бүртгэгчийн 2 нь мэдүүлэг хүлээн авах, 2 нь боловсруулалт хийж, ажлын хуваарийн графикын дагуу сар сараар солигдож ажилладаг.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баян-Өлгий аймгийн хэмжээнд Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Улаанхус, Цагааннуур сум зэрэг 5 сумаас үзүүлж байсан энэ онд нэмж Бугат, Буянт, Баяннуур, Булган, Сагсай сумуудад эд хөрөнгийн бүртгэл хөдлөх эрх, Монгол улсын засгийн газраас баталсан "Шинэ хоршоо Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчдийг чадавжуулах сургалтын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан онлайн болон танхимаар сургалт явуулж 8 сумд хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээлгэж, хурдан шуурхай ажиллаж байна.

**ГАТЭМ**  
 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХҮРЭГЛЭЛЭН  
 ДАТГА 1

**ХҮҮЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ 2023 ОНЫ АРГААРИЙН ГЭЖИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХҮРЭГЛЭЛЭН УЛСЫН БҮРТГЭЛ 2023 ОНЫ ҮЙЛЧИЙН ХАНАГЧИЙН ТАЛАНГААНЫ ХАНАГЧИЙН**  
**САНГААНЫ ТАЛАНГААНЫ**

Ажл.	Аргачлал	Бүртгэлийн нэр	Хүрээ	Хүрээгээр хийгдсэн ажил үйлчилгээ
<b>Ажлын бүртгэл</b>				
1	Төлөөлөгч, туслах, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	1. Тус бүртгэлд үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2023.05.27-ны өдөр 28.00 дахь	Улсын бүртгэл, Х.Тамгач
<b>Үйлчилгээний бүртгэл</b>				
2	Бизнес, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2. Үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2023.05.29-ны өдөр 30.00 дахь	Улсын бүртгэл, Х.Тамгач
<b>Самууны бүртгэл</b>				
3	Самуунч, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	3. Самуунч, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2023.05.31-ны өдөр 32.00 дахь	Улсын бүртгэл, Х.Тамгач
<b>Ажлын бүртгэл</b>				

Ажл.	Аргачлал	Бүртгэлийн нэр	Хүрээ	Хүрээгээр хийгдсэн ажил үйлчилгээ
4	Төлөөлөгч, туслах, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	4. Төлөөлөгч, туслах, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2023.06.05-ны өдөр 35.00 дахь	Улсын бүртгэл, Х.Тамгач
<b>Үйлчилгээний бүртгэл</b>				
5	Бизнес, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	5. Үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2023.06.05-ны өдөр 37.00 дахь	Ажлын бүртгэл, Х.Тамгач
<b>Самууны бүртгэл</b>				
6	Самуунч, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	6. Самуунч, үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан, хуульч, судлаач, урьдчилсан үнэлгээний үйлчилгээний хэлтэст ажилладаг ажилтан	2023.06.07-ны өдөр 39.00 дахь	Улсын бүртгэл, Х.Тамгач

Төлөөлөгч, туслах  
 Улсын бүртгэл, Х.Тамгач


### **3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:**

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 1320 бүртгэл хийсэн байна. Үүнд: Шинээр бүртгэсэн ТБАГ 6, ХХК 153, ХК 1, ТББ 24, Хоршоо 285, Нөхөрлөл 2, Сан 2, Салбар 4, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 298, дахин гэрчилгээ 84, нэрийн баталгаажуулалт 388 байна. Хуулийн этгээдийн татан буугдах 3 бүртгэл бүртгэсэн. Тамга, тэмдгийн хяналтын 583 дугаар олгож, оноосон нэр өөрчлөгдсөн болон ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 73 тэмдэг хурааж авсан. 2023 онд шинээр ТБАГ 4, ХХК 87, ТББ 13, Хоршоо 4, Нөхөрлөл 10, Сан 2, ҮЭХ 4, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 204, дахин гэрчилгээ 23, нэрийн баталгаажуулалт 310, 2 хуулийн этгээдийн татан буугдах бүртгэлийг бүртгэж, Тамга тэмдгийн 174 хяналтын дугаар олгож, ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 41 тэмдэг хурааж авч байсныг энэ онтой харьцуулахад ТБАГ 2 нэгж, ХХК 1,5 дахин, ТББ 10 нэгж, Хоршоо 70 дахин өссөн бол Нөхөрлөл 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. Нэмэлт өөрчлөлт 94-өөр, нэрийн баталгаажилт 78-аар, тамга хэмдгийн хяналтын хуудас 2 дахин, хураасан тамга тэмдэг мөн 32-оор өссөн үзүүлэлттэй байна. Хоршооны бүртгэл 70 дахин өссөн нь хэлтэст нэмж 1 улсын бүртгэгчид, сумдын 8 улсын бүртгэгчид эрх нээлгэж "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий үеэр зохион байгуулалтын арга хэмжээ авч бүртгэл хийлгэсэнгүй холбоотой болно.

Цахимаар илгээсэн 1489 нэрийн хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Өнгөрсөн оны мөн үед 707 хүсэлт шийдвэрлэж байсныг харьцуулбал 2 дахин өссөн байна.

Сар бүрийн бүртгэлийн тоон мэдээ гарсны дараа архивчтай мэдээгээ тулган ажиллаж байгаа ба 2024 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 3047 хувийн хэрэг архивт хадгалагдаж байна.

Тайланг хугацаанд Хуулийн этгээдийн цахим мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд 76 дүрмийн хуулбар, 39 лавлагаа гаргаж өгч 8 төрийн бус байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэж авсан болно. Өнгөрөгч онтой хуулбарыг харьцуулахад хэвийн түвшинд, лавлагаа 3 дахин багассан нь цахимаар лавлагаа авч байгаатай холбоотой болно. Мөн өмнөх онд 25 төрийн бус байгууллагын тайлан хүлээж авч байсныг харьцуулахад 3 дахин багассан болно.



Хүснэгт 5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд зөргүйтэй бүртгэгдсэн болон тамга, тэмдгээ үрэгдүүлсэн 7 хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч дүгнэлт гаргуулахаар Хэлтсийн хяналтын улсын байцаагчид шилжүүлэн 2 дүгнэлт гаргуулж бүртгэсэн байна.

Тайланг хугацаанд шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 745 бүртгэлийн бүрдүүлбэр, бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлэн ажиллав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2024 оны эхний 11 сарын тоон мэдээг хугацаанд үнэн зөв гаргаж, ХЭУБГ-т хүргүүлсэн.

Үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр Хэлтсийн нягтлан бодогч, нярав нарт үнэн зөв гаргаж өгч ажилласан.


Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж удирдлагад танилцуулан ажилласан. Тухайлбал, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа болон шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой бүртгэсэн бүртгэлийн тайланг холбогдох судалгааны хамт ХЭУБГ-т хүргүүлсэн.

УБЕГ-аас хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зохион байгуулсан 12 удаагийн онлайн сургалтад оролцсон. УБЕГ-ын Хүний нөөцийн нэгдсэн системд байршуулсан Хуулийн этгээдийн хичээлийг бие даан судалж, холбогдох шаглалтыг амжилттай өгсөн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ХХК цахимаар болон биечлэн ирж бүртгүүлэх талаар контент бэлдэж, мэдээллийг фейсбук, социал сүлжээгээр олон нийтэд түгээн ажиллав.

Засгийн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд аймагт зохион байгуулагдсан удирдах ажилтны сургалтад оролцож мэдээлэл хийж орон нутгийн радиод ярилцлага өгч малчид иргэдийг мэдээллээр хангаж ажилласан. Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тус аймагт үйл ажиллагаа явуулдаг 23 төрийн байгууллагад хэлбэр өөрчлүүлэн дахин гэрчилгээ авах талаар Мэдэгдэх хуудас хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан болно.

Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээлгэсэн сумдын улсын бүртгэгч нарыг чадавхжуулах сургалтыг 3 удаа зохион байгуулсан.



ХЗУБГазар болон Хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлж тайлагнаж ажиллав.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 49 албан тоот, 5 өргөдлийг хүлээн авч хариутай албан тоот, өргөдөлд хугацаанд нь хариу хүргүүлж ажилласан болно.


Шүүхээр хянагдаж байгаа хэрэг маргааны судалгааг хяналтын улсын байцаагчид гаргаж өгч ажиллаж байна.

ҮАБЗ-ийг мэдээ, мэдээллээр хангах аймгийн ажлын хэсэгт тус аймагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн шашны болон төрийн бус байгууллагуудын талаар танилцуулга, холбогдох дэлгэрэнгүй судалгааг журамд заасны дагуу хүргүүлж ажиллав. Аймгийн ЗДТГ-т тус аймагт үйл ажиллагаа явуулдаг Шашны байгууллагуудын болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн төрийн бус байгууллагуудын, Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой шинээр байгуулагдсан хоршоодын, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн судалгаа, Татварын газарт 2024 оны эхний хагас жилд бүртгэгдсэн хуулийн этгээдийн судалгаа, аймгийн Сонгуулийн хороонд орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн хуулийн этгээдтэй эсэх талаарх судалгааг тус тус гаргаж өгч хамтран ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу Сангийн яамнаас УБЕГ-т хүргүүлж албан ёсны цахим хаягт байршуулан нийтэд зарласан 12447 хуулийн этгээд болон эцсийн өмчлөгчөө бүртгүүлээгүй хуулийн этгээдийн талаар орон нутгийн радио болон олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэсэн.

### 3.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа

Тус хэлтсийн Хяналтын улсын байцаагч нийт 22407 бүртгэлд байнгын хяналт тавьж, 20685 бүртгэлийг шалгасан болно. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн 9398 бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 5030 бүртгэл, Хуулийн этгээдийн 1188 бүртгэл, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 5069 бүртгэлийн эх нотлох баримтад байнгын хяналт тавьж шалгасан болно.



Хяналт шалгалтаар илэрсэн 220 бүртгэлийн зөрчлийг зөрчлийг таслан зогсоож, арилгуулах арга хэмжээ авч нийт 94 бүртгэлийг хүчингүй болгосон, зөрчил арилгах тухай 160 дүгнэлт тус тус үйлдсэн байна.

Улсын хууль тогтоомжийн биелэлтэд байнга хяналт тавьж зөрчсөн 4 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх санал, гэмт хэргийн шинэтэй байж болзошгүй 2 үйлдлийг шалгуулахаар үүргийн дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн болно. Нийт 10940 иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох 160 дүгнэлт үйлдсэн байна. Бүртгэлийн зөрчлийг арилгуулах тухай 15 албан шаардлага, 7 мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан болно. Тус хэлтэст гаргасан 1534 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл хүсэлт, 15 иргэний гомдлыг хүлээн авч хууль журмын дагуу шийдвэрлэж хариу өгсөн байна.

Мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн буюу Зөрчлийн тухай хуульд заасан нийт 107 иргэн хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг шалган шийдвэрлэсэн, 4215000 төгрөг торгуулийг бүрэн төлүүлсэн Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлт хангуулан ажилласан байна.

Улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлж 15 шүүх хуралд хариуцагчаар орж, үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн болно.



### **3.5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн талаар**

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2-3/1068 дугаартай албан бичгийн дагуу МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Иргэний бүртгэлийн газраас зохион байгуулсан сургалтанд хэлтсийн дарга болон улсын ахлах бүртгэгч цахимаар оролцов. Сонгуулийн тухай хуулийн хүрээнд Сонгуулийн Ерөнхий хорооноос болон ИУБГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд хамрагдсан. Сонгуулийн тухай хуулийн танилцуулга сургалтыг дотооддоо зохион байгуулсан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6/1281 тоот албан бичиг болон Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний 19 дэх хэсэгт “Засаг захиргааны анхан шатны нэгжийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор /баг, хороо шинээр байгуулагдсан иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг шалгаж, тулгах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Тус аймаг нь 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулиар 97 баг болон 97 хэсэгтэйгээр сонгуулийн үйл ажиллагааг явуулж өнгөрүүлсэн. Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 73 дугаар тогтоолоор тус аймгийн Ногооннуур сумын 5 дугаар багаас 10 дугаар баг/Шар говь/-ийг, 7 дугаар багаас 11 дүгээр баг /Морин толгой/-ийг, 4 дүгээр багаас 12 дугаар баг /Цагаан буур/-ийг тус тус шинээр байгуулсан. Мөн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор 2019 оны 73 дугаар тогтоолын зарим хэсэгт өөрчлөлт оруулсан.

Ногооннуур сумын Засаг даргын албан бичиг болон холбогдох нотлох баримтыг хэлтсийн даргын 01/233 тоот албан бичгээр Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан. Одоогоор тус аймаг мэдээллийн санд бүртгэлтэй 100 багтай болно. Өнгөрсөн жил шилжилт хөдөлгөөний бүртгэлээр шинээр байгуулагдсан 10 дугаар буюу Шарговь багт 10 гаруй иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэсэн. 11 дүгээр баг Морин толгой, 12 дугаар баг Цагаан буур багууд газрын маргаантай учраас нэг ч иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэж чадахгүй байгаа учраас сумын удирдлагуудад удаа дараа хүсэлт тавьсанаар аймгийн ИТХ-ын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 238 тоот тогтоолоор тухайн багуудын хилийн заагийг тогтоосон.



Тус сумын шинээр байгуулагдсан 3 багийн иргэд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл болон ЗГ-ын 332 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын 2.2 заасан оршин суугаа хаягаа нотлох баримт бичиг газрын гэрчилгээ байхгүй ойрын хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэлээр орох боломжгүй болсон талаарх сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/13 тоот албан бичиг болон тухайн багуудад холбоотой гарсан холбогдох нотлох баримтуудыг үндэслэн тус хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 205 дугаар дүгнэлтээр 10 дугаар баг буюу Шарговь багт 464 иргэний, 293 дугаар дүгнэлтээр 11 дүгээр баг буюу Морин толгой багт 354 иргэний, 294 дугаартай дүгнэлтээр 12 дугаар баг буюу Цагаан буур багт 530 иргэний мэдээллийг нэмэлт өөрчлөлтийг тусгуулахаар хэлтсийн даргын 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 94,95,96 тоот албан бичгээр Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Хэрвээ эдгээр багуудын иргэд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр орсон тохиолдолд манай аймгийн хувьд сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан асуудалгүй болохыг илтгэх хуудсаар хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 3/1578 дугаартай албан бичгийн дагуу ирүүлсэн өөрийн байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй иргэдийн мэдээллийг шалгахар хандсан иргэдээс мэдээлэл нь зөрүүтэй гэсэн 5 иргэний мэдээллийг хүлээн авсан. Ирсэн жагсаалтын дагуу холбогдох мэдээллийг тодруулан иргэдтэй утсаар холбогдон тодруулсан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 2/3440 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт заасны дагуу сумдын ИТХ-ын тогтоолыг хянах явцад Хяналт шалгалтын газраас ирүүлсэн зөрчлийн тэмдэглэлд 6 сумын тогтоолыг зөрүүтэй хэмээн үзсэн байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, 13.6, 13.7 заалт болон 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 24, 26, 27 заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ирсэн тогтоолыг хүлээн авч хянаж үзээд буруу гарсан зарим сумдын тогтоолуудыг сумдын ИТХ-ын ажлын албанд дахин хүргүүлж зөвтүүлэн гаргуулах ажлыг хийж, эрх нээгдсэний дагуу улсын ахлах бүртгэгч 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрөөс шивж эхлэн 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 18 цаг хуртэл хийж гүйцэтгэн баталгаажуулж дуусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дах заалт болон 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 30,31 дугаарт заасан болон ИУБГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөс сонгогчдод хэсэг оноосон байдлыг хэсэг тус бүрээр нягтлан тулгаж үзээд хэсэггүй сонгогчдын тайлангаас хэсэг оноогдоогүй үлдсэн 21 сонгогчын хэсгийг оноосон.

Тус аймгийн 97 хэсэгт нийт 69317 сонгогч бүртгэгдэж, хэсэг оноогдоогүй болон буруу оноогдсон сонгогч байхгүй болно.

Тус аймгийн сумдыг хариуцан ажиллаж байгаа улсын бүртгэгч нарт <http://election.gasr.mn/> программд нэвтэрч харах эрхийг нээлгүүлэн хэсэг оноолтыг зөв оноосон эсхийг шалгуулж илтгэх хуудсаар хариу хүргүүлсэн.

2024 оны 03 сарын 29-ны өдөр УБЕГ-аас 594 иргэний БДӨБ-г шалгах жагсаалт ирсэн. Үүний дагуу зураг засах программаас шалгаж зөрчилгүй тухай илтгэх хуудас хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дах хэсэгт заасныг үндэслэн гаргасан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/61 тоот тушаал болон ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 17 цагт багтааж бүх ажиллагааг хийж дуусгасан. Мөн тухай өдөр сумдыг хариуцан ажиллаж байгаа улсын бүртгэгч нараас шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоосон талаар өөрсдийн дотоод сүлжээгээр дамжуулан хамгийн сүүлд бүртгүүлсэн иргэний нэртэй зургийн баталгажуулан авч 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өглөөний 11 цагт бүх маягт журналыг эх хувиар хүлээн авсан болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дах заалт болон 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 71,72 дугаарт заасан болон ИУБГ-аас өгсөн чиглэлийн хүрээнд 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн сонгуулийн тухай хуулийн 20.6 заасны дагуу УДШ, ШШГЕГ, ХХЕГ, БХЯ, ЦЕГ-аас ирүүлсэн мэдээлэлд хэсэг оноосон байдлыг нягтлан тулгах ажлыг дээрх байгууллагын удирдлагуудад мэдэгдэн байгууллагаас явуулсан жагсаалтыг төлөв зөв оноогдсон эсхийг тулгалт хийсэн. Төрийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд 540 сонгогч бүртгэгдсэн.

Хэсэг оноогдсон байдлыг үзэхэд сонгуулийн тухай хуулийн 20.6-ын


- 20.6.2 заасны дагуу хорих анги, албадан эмчилгээ - 56 сонгогч
- 20.6.3 заасны дагуу гадаадад 60 ба түүнээс дээш хоногоор зорчсон -7664 сонгогч
- 20.6.4 заасны дагуу тусгай анги салбарын албан хаагч, ажилтан – 61 сонгогч
- 20.6.5 заасны дагуу зэвсэгт хүчний цэргийн ангийн албан хаагч – 10 сонгогч
- 20.6.6 заасны дагуу цагдаагийн албан хаагч, дотоодын цэрэг – 40 сонгогчын төлөв тус тус тусгагдан орсон байна.

Тус аймгийн сумдыг хариуцан ажиллаж байгаа улсын бүртгэгч нарт өөрсдийн хариуцан ажиллаж байгаа сумдын хэсгийн мэдээллийг сонгуулийн тухай хуулийн 20.6 –д заасан мэдээлэл зөв тусгагдсан эсэхийг шалгуулж илтгэх хуудсаар хариу авсан болно.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад Эрх зүйн сургалтыг 2024 оны 05-р сарын 30-ны өдөр зохион байгуулав.

Хууль заасан ажлын хүрээнд сонгогчдын нэрийн жагсаалтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 4 хүнд эрх нээлгүүлж УБЕГ-ын ажлын хэсгээс гаргасан хувиарын дагуу 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн өглөөний 9 цагаас эхэлж сонгогчдын нэрсийн жагсаалтыг хэвлэсэн. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд

заасны дагуу хэсгийн хороодод хүргэх ажлыг хуульд заасан хугацаанд сумдын сонгуулийн хороодод хүргэж өгсөн болно.



"Түр хасав" тэмдэглэгээтэй 7645 сонгогч бүртгэлтэй байна. Сумдын улсын бүртгэгчдээс ирүүлсэн Түр хасав төлөвтэй иргэдийн төлөв сэргээх хүсэлтийг нь хүлээн авч нийт 67 сонгогчын түр хасавыг сэргээсэн.

Хууль заасан ажлын хүрээнд сонгогч шилжилтийг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр 3 хүнд эрх нээлгүүлж 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хэсгийн хороодоос ирүүлсэн сонгогч шилжих материалыг хүлээн авч 2 бүртгэгч, ахлах улсын бүртгэгчийн эрхээр оруулан лавлагааг 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хэвлэв. Нийтдээ 1481 лавлагаа үүнээс:

1. Иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт хасах лавлагаа – 1
2. Иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт нэмэх лавлагаа – 1
3. Регистрийн дугаар өөрчилсөн засах лавлагаа - 1
3. СХ-ийн 23,2, 23,4 үндэслэн сэргээсэн засах лавлагаа – 6
4. Нас барсан хасах лавлагаа – 37
5. Сонгогч шилжин ирсэн нэмэх лавлагаа – 622
6. Сонгогч шилжин явсан хасах лавлагаа – 634
7. Гадаад санал өгөх хасах лавлагаа - 179

Хууль заасан ажлын хүрээнд сонгогчдын нэрийн жагсаалтыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр УБЕГ-аас ирсэн сургалтын багтай хамтарч хэсгийн хороодод ажиллах 100 итгэмжлэгдсэн ажилтануудыг оролцуулсан сургалтыг зохион байгуулж, СНЖ-аад оруулсан өөрчлөлтийг УБЕГ-ын МТГ-аас ирсэн программист Дэлгэрмөрөн 97 хэсгийн 1481 лавлагааг тусгасны дараа:

1. Сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгогчдын тоо – 69865
2. Хасагдсан – 8364
3. Лавлагаа тусгагдсан байдлаар бусад сонгогчдын тоо – 61501 сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэсэн.

Хэвлэсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг хуудас нэг бүр болон лавлагаа тусгагдаж хэвлэгдсэн мэдээллийг сонгогчийн мэдээллийн сангай тулган шалгаж, хэлтсийн дарга хянаж гарын үсэг зурж тэмдэгээр баталгаажуулав. СНЖ-ыг 2 хувь хэвлэж 1 хувийг хэсгийн хороонд, 1 хувийг итгэмжлэгдсэн ажилтанд олгосон болно.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасны дагуу хэсгийн хороодод итгэмжлэгдсэн ажилтаны тоног төхөөрөмжийн хамт хүргэх ажлыг зохион байгуулж, сумдын сонгуулийн хороодод хүргэж өгсөн болно.

Санал хураалтын өдөр гарсан асуудлыг тухай бүр яаралтай шийдвэрлэж нэрсийн жагсаалтад бичигдсэн 69014 сонгогчоос 46330 сонгогч буюу 73,6% санал өгөх ажиллагаанд оролцов.


Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэн тус аймгийн 100 багийг 100 хэсэг болгон хуулийн хугацаанд хийж хэрэгжүүлэн ажиллав. Бүх ажлыг хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж тухай бүр илтгэх хуудсаар ерөнхий газарт хүргүүлэн ажилласан болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 61,62,63,64,65 дугаар зүйл заалтууд болон 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 62,63,64 дугаарт заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

УБЕГ-ын даргаас өгсөн үүрэг даалгавар болон ажлын хэсгээс өгсөн чиглэл аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу тус аймагт санал хураалт 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн өглөөний 07 цаг буюу орон нутгийн цагаар 06 цагт эхлэв. Сонгуулийн 100 хэсэгт тоног төхөөрөмж ажиллаагүй шатсан ноцтой асуудал гараагүй бүгд хуулийн хугацаанд мэдээгээ дамжуулав. Тухайн өдөр Сагсай сумын 2-10-2 хэсэг зөвөрийн хайрцаар авсан иргэдийн мэдээллийг ирцийн бүртгэлээр оруулсан зөрчил гаргасан. Мөн Баяннуур сумын 2-4-1 хэсэгт өөр хэсгийн нэг сонгогч С.Еркежан /ББ97033007/ нь хурууны хээ уншуулахад 2-4-1 хэсгийн сонгогч Ж.Хундз /БВ00282726/-ын мэдээлэл гарч ирсэн байна. Тухайн иргэнийг сонгуульд оруулж зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Санал хураалт хуулийн хугацаанд дуусны дараа тус аймгийн Булган сумын 2-2-6-7 хэсэг, Ногооннуур сумын 2-9-6 хэсэг, Улаанхус сумын 2-12-2 хэсэг, Цэнгэл сумын 2-13-5 хэсэг буюу 4 газарт нэмэлт санал хураалт явагдах болсон. Сумын сонгуулийн хорооноос гарсан шийдвэр болон УБЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2-12-2 оос бусад 3 хэсгийн санал хураалтыг 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн өглөөний 07-20 цагийн хороонд зохион байгуулж ажиллав.

Санал хураалтын өдөр ямар нэгэн асуудал гараагүй ба гарсан асуудлыг тухай бүр яаралтай шийдвэрлэж нэрсийн жагсаалтад бичигдсэн 69379 сонгогчоос 48785 сонгогч буюу 76,3% санал өгөх ажиллагаанд оролцов.



## Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Цахим гарын үсгийн тухай хууль эцэслэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн иргэдэд олгож эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар тус хэлтсээс 56,139 иргэн тоон гарын үсгээ авсан ба гар утасны Gsign аппликейшинд 5,995 иргэний үнэмлэхэд 50,144 иргэн авсан байна.

Энэ нь Баян-Өлгий аймгийн 16-аас дээш насны нийт иргэдийн 73.8 хувьд олгосон байна. 2024 онд нийт 7891 иргэн тоон гарын үсэг авснаас Gsign аппликейшинд 4,190 иргэний үнэмлэхэд 3,701 иргэн авсан байна.

Тоон гарын үсэг олголтыг нэгжээр харуулбал 2024/01/01-2024/11/21

Нэгжийн нэр	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар
Баян-Өлгий /хэлтэс/	88	61	65	87	65	71	122	101	126	35	40
Баяннуур сум	54	26	39	141	45	39	1	0	0	0	14
Алтанцэг сум	33	109	61	101	45	11	4	8	0	4	3
Ногооннуур сум	83	217	105	161	71	46	7	3	52	27	23
Алтай сум	167	226	136	89	75	34	28	0	42	35	10
Цэнгэл сум	61	659	212	303	90	168	46	7	55	32	12
Далуун сум	83	36	12	29	37	26	41	16	41	19	31
Толбо сум	12	23	14	15	7	2	2	2	5	11	8
Буянт сум	53	139	61	101	22	27	1	14	21	5	4
Улаанхус сум	70	125	40	83	40	9	7	7	46	35	18
Цагааннуур тосгон	45	65	28	60	35	34	49	15	10	8	11
Булган сум	70	107	50	17	10	61	27	8	12	1	0
Өлгий сум	40	22	5	27	1	0	6	8	0	0	3
Сарсай сум	92	121	17	55	28	14	5	2	22	4	20
Бугат сум	61	96	36	73	32	23	11	8	33	17	5
Нийт	1,012	2,032	881	1,342	603	565	357	199	485	233	202

### Хүснэгт 8. Нэгжийн тоон гарын үсэг олголтын тоон мэдээ

Тоон гарын үсэг олголтыг УБЕГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу эрчимжүүлэх ажлын хүрээнд бүх албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд албан бичиг хургуулан, радио, телевизд ярилцлага өгч, томоохон аж ахуй нэгж албан байгууллагуудад очиж тоон гарын үсэг олгох, сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан.



## Тав. Архив, албан хэрэг хөтөлтийн үйл ажиллагаа

2024 оны байдлаар иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр ХААТР-11 төрөлт-2113, ХААТР-12 үрчлэлт-91, ХААТР-13 овог эцэг-эхийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-53, ХААТР-14 эцэг тогтоолт- 11, ХААТР-15 гэрлэлтийн бүртгэл- 505, ХААТР-16 гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-50, ХААТР-18 нас баралт-497, аймаг нийслэл рүү шилжин ирсэн-823, ИБЗ-1 мэдээлийн санд нөхөн бүртгэлд оруулах-20, ИУБ-31 Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-4169 буюу нийт 7509 маягтуудыг журмын дагуу хүлээн авч баримтыг хувийн хэрэгт баяжилт хийсэн болно. ХААТР-22 1702ш хүлээн авч журмын дагуу хадгалагдаж байна. Одоогийн байдлаар иргэний бичиг баримтын архивт нийт хувийн хэргийн тоо 174,364 ХААТР маягт хадгалагдаж байна. Иргэний 8 төрлийн бүрдүүлвэр болон дэвтэр, гадаад паспортын бүрдүүлбэрүүдийг жилийн эхэнд нийт 583 хадгаламж нэгж хүлээн авсан болно.

Регистрийн дугаар буруу, хүйс зөрүүтэй, ХААТР маягт нөхүүлэх мэдээллийн санд ороогүй, нас тогтоолгох, төрөлт тогтоох, нас баралт тогтоох, шүүхийн журмаар гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн зөрчлийг арилгахын тулд нийт 1157 хувийн хэргийг Архивын фондоос захиалгын хуудсаар бүртгэл хөтөлж Улсын бүртгэгч, Хяналтын улсын байцаагч нарт гаргаж өгөх, хүлээн авч буцаан байрлуулан ажилласан.



Тайлант жилийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт нийт 929 хувийн хэргийг шинээр архивт хүлээж авч шинээр нээсэн хувийн хэрэг бүртгэх маягт дэвтэрт бүртгэж улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу хаяглаж архивт байршуулсан болно.

Үүнд: газар өмчлөлийн анхны бүртгэл 238, газар эзэмших 4877, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн анхны бүртгэл 691, ашиглах эрхийн 6 хувийн хэрэг орсон байна. Хүчингүй болж хаагдсан 195 хувийн хэрэг байна.

Мөн улсын бүртгэгч нарын өдөр тутам хүлээж авсан нэмэлт өөрчлөлт, худалдах худалдан авах гэрээ, бэлэглэх гэрээ, өө залгамжлах гэрээ, барьцааны гэрээ, лавлагаа, хуулбар зэрэг нийт 5037 гаруй нотлох баримтуудыг архивт хүлээж авч хувийн хэргийн байжилтыг цаг тухайд нь хийж байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 35267 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүний: 16747 нь газраас бусад үл хөдлөх

эд хөрөнгө, 13920 нь газар өмчлөл, үлдсэн 4877 газар эзэмших эрхийн бүртгэл, 6 нь ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг байна.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн 479 анхны бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээж авч улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу байршуулсан болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид бүтэн жилийн хугацаанд 365 гаруй хувийн хэргийн баяжилтыг хүлээн авч цаг тухайд нь зохих журамны дагуу байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 3,047 хувийн хэрэг хадгалагдаж байна.

### **Зургаа. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт**

Хэлтсийн үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж ирсэн ба санал хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна. Өдөр тутмын үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн үйлчилгээ, зан харилцааны асуудлаарх иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тухай бүр хэлтсийн дарга биечлэн хүлээн авч шийдвэрлэн, иргэдэд ойлгомжгүй байгаа асуудлыг Тасгийн дарга нараар тайлбарлуулан иргэдэд үйлчилж байна. Авлига, ашиг сонирхол зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй байна.

ХЗДХЯ-ны салбарын цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем "E-DOC" <https://edoc.mojha.gov.mn/> программыг хэрэглээндээ бүрэн нэвтрүүлэн ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 1276 албан бичиг хүлээн авсан байх ба ажилласан хугацаанд нийт 1216 албан бичиг гадагш явуулсны 900 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хэлтсийн даргын "А" тушаал 9, "Б" тушаал 15 нийт 24 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 2024 оны 11 дүгээр сарын 25-ны хүртэлх хугацаанд иргэдээс нийт 120 өргөдөл хүлээн авч, холбогдох албан хаагч бүрт танилцуулан хувиарлан хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлсэн.

Үүнээс: Захиргаа удирдлагад /хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, эд материал, санхүүгийн дэмжлэг, албан хаагчдын чөлөө хүсэх, талархал г.м/ 7 өргөдөл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 2, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 7 өргөдөл ирсэн байх ба Иргэний бүртгэл болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргахтай холбоотой /үрчлэлт, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэрлэлт дууссавар болсныг бүртгүүлэх мөн регистрийн дугаар зөвтгөх, гэрчилгээ дахин олгох, тодорхойлолт, лавлагаа олгох зэрэг/ 104 байна.

2024 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар 120 иргэний өргөдлөөс 116 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 1, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 4 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 93.1%-тай байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа

болно. Өргөдөл гомдлын мэдээг сар бүр 25-наар тасалбар болгон мөн загвар хүснэгтийн дагуу улирлын сүүлийн сарын 20-ноор тасалбар болгож УБЕГ, ЗДТамгын газрын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд хэлтсийн даргаар баталгаажуулан хүргүүлж байна.

Мөн хэлтсийн <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/> цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулж байгаа болно.

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаарх албан даалгаврыг ажилтнууддаа танилцуулан, хэлтсийн ажилтнуудын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан, өглөө болгон цагийн бүртгэлтэй танилцаж, чиглэл өгч ажилласан. Сумдын анхан шатны бүртгэгчдийн цаг ашиглалтын байдалд сумын Засаг даргын тамгын газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.

### **Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Байгууллагын цахим хуудас, санхүүгийн үйл ажиллагаа /**

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам", Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан "Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг", Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн цахим хуудас нь <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/> гэсэн хаягтай. Тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэлийн үйл ажиллагааг тус цахим хуудсанд 75 мэдээлэл байршуулсан ба олон нийтэд түгээх зорилгоор мэдээллийг фото зургийн хамт олон нийтийн социал сүлжээ буюу <https://www.facebook.com/bayanulgii.burtgel> фэйсбук нэйж хуудсаар мэдээллийг давхар түгээж ажилласан байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан шэйр хийж байна. Өнөөдрийн байдлаар 3965 дагагчтай болсон байна. 2024 онд социал хуудсаар дамжуулан 161 бүртгэлтэй холбоотой мэдээлэл түгээсэн байна.

Цахим хуудасны танилцуулга цонхонд нэгжийн бүтэц, албан хаагчдын мэдээлэл, ил тод цонхонд хүний нөөцийн ил тод байдал, шилэн данс, хурал, сургалт, семинарын зар, улирал, жилийн тайлан, хэрэглэгч танд цонхонд түгээмэл асуулт хариулт, нээлттэй ажлын байрны зар, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал, сар бүрийн тоон мэдээ, холбоо барих цонхонд байгууллагын хаяг, байршил, ажиллах цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах цаг, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах утасны дугаар, шуудан хаяг зэргийг нээлттэй байршуулсан болно. <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/sar-buriin-toon-medeelel>

Нүүр хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео мэдээллүүд, аймгийн танилцуулга, түүх болон дурсгалт газрууд, фото зургийн цомог, мөн аймгийн далбаа, газрын зургийг бүрэн оруулсан.





Баннер хэсэгт төрийн үйлчилгээний E-mongolia цахим систем, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах Burtgel.mn систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээлэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.

Цахим хуудасны хөл хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google map дахь газрын байршилыг харуулсан болно.

Тус хэлтэс нь батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар улсын төсвөөс 1.300.659.200 төгрөг, нэмэлт санхүүжилтээр УБЕГ-аараас УИХын сонгуульд 103.868.775 төгрөг АНСДИТХ-ын сонгуулийн ажилд 97.872.300 төгрөг, Орон нутгаас 81.245.750 нийт 1.583.646.025 төгрөгийн санхүүжилт авснаас 1.514.789.096 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба энэ нь нийт төсвийн 95.0% байна. Мөн тайланг хугацаанд 141.666.666 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсанаас 148.882.926,8 төгрөгийн орлого оруулж, Сангийн Яам Улсын Төсөвт 146.413.126,8 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн болно. Орлогын төлөвлөгөөг 103 %-иар биелүүлсэн болно. Сар бүрийн 2-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан ба өглөг авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээг УБЕГ-т хүргүүлж ажиллаж байна. Үнэт цаасны зарцуулалтын тайлан болон үлдэгдлийн тайлан, иргэний үнэмлэхийн орлогын тайланг хугацаанд нь дээд газарт хүргүүлж ажиллаж байна. Мөн түүнчлэн ХАОАТ болон НДШ-ийн тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хуулийн хугацаандаа хүргүүлсэн. Хэлтсийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгүүлж "Зөрчилгүй" дүгнэлт авсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүд болох тухай бүр оруулах 100ш сар бүр оруулах 40, хагас жилээр оруулах 4, жил бүр оруулах 5 мэдээллүүдийг хуулинд заасан хугацаанд нь оруулж ажиллаж байна. Үнэт цаасны тооцоог сар болгон албан хаагч бүртэй хийж, үлдэгдэл үнэт цаасыг тулган ажилласан. Мөн бүсийн сургалт семинар болон УИХ, АНСДИТХ-ын сонгуулийн ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн болно.

Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст 2024 оны төсөв болон орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-10 дугаар сарын мэдээнүүдийг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан. Мөн 11 сарын байдлаар Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 24.891.140 төгрөгийн үнэт цаас бараа материал 3.660.580 төгрөгийн үнэ бүхий

үндсэн хөрөнгийг хүлээн авч санхүүгийн тайландаа тусгасан болно. Хэлтсийн эд хөрөнгийн тооллогыг хэлтсийн даргаар тушаал гаргуулан хагас жилээр хийж гүйцэтгэх ажлыг ханган ажиллаж байна.

### Найм. Сургалтын төлөвлөгөөг тайлагнах ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн албаны зөвлөл, Бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 33 удаагийн сургалтад давтагдсан байдлаар 805 албан хаагч хамрагдсан байна. Хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөө боловсруулж, баталуулан, төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалчилах зорилгоор нийт 15 сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд 10 дотоодтой, 5 бусад байгууллага, албан тушаалтан нартай хамтран зохион байгуулав.

УБЕГ-аарын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 17 удаагийн сургалтад албан хаагчид цахимаар бүрэн хамрагдсан. Хүний нөөцийн сургалтын системийн Бие даан хийх хичээлийн хэсгийг улсын бүртгэгч нарт судлуулан шалгалтыг нь өгч ажилласан болно.

Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 зохион байгуулсан сургалтад нийт 7 удаагийн сургалтад албан хаагчид тухай бүр хамрагдсан байна.

Дотооддоо зохион байгуулагдсан сургалтуудаас дурьдвал.

- Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эцэг, эхийн зөвлөлөөс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран хэлтсийн албан хаагчдад "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сэдэвт сургалт зохион байгуулав. Сумдын улсын бүртгэгч нар цахимаар хамрагдсан.



- Засгийн газраас "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон. Уг ажлын хүрээнд тус хэлтсээс шинэ хоршоог e-business цахим системээр байгуулах, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, анхаарах асуудлын талаар сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион мэдээлэл арга зүйгээр ханган ажилласан.




- 2024 онд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жил болж буйтай холбогдуулан Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтад хэлтсийн дарга Х.Амангүл оролцсон.



- Хяналтын улсын байцаагч А.Еркегүл "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүртгэл хөтлөх явцад анхаарах асуудал" сэдвээр сургалт хийсэн.

- "Төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэхэд анхаарах зүйлс" сэдвээр МУБИС-Багш, Насан Туршийн Боловсрол БоСС-ийн Насан туршийн суралцахуйн төвийн оюутан Б.Байгалмаа, СӨБ, ЕБС-ийн "Дэмжлэгийн баг"-ийн үйл ажиллагааны талаар мөн аймгийн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааны талаар "Насан туршийн суралцахуйн төв"-ийн захирал Б.Бахытгүл нар сургалт зохион байгуулсан.



- Өлгий сумын ЗДТГ-ын ажлын албаны шуурхай хуралдаанд Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Д.Аманбек оролцож тус сумын хаягийн асуудлын талаар, 02-р сарын 8,9 ний өдрүүдэд аймгийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтэнүүд болон сумдын ЭМТөвийн эрхлэгч, өрхийн эмнэлгүүдийн эрхлэгч, аймгийн төрөх тасгийн эмч, сувилагч нарыг оролцуулсан дундын мэдээллийн сангаар олгогдож байгаа регистрийн дугаар, төрөлтийн бүртгэлийн СТ-4 маягт, нас баралтын бүртгэлийн АМ-7 маягт олгох явцад гарч буй зөрчил цаашидаа хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөлдөх онлайн хурлыг зохион байгуулж ажилласан.

УБЕГ-ын сургалтын багтай хамтран Монгол Улсын Их Хурлын болон АНСДИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар тус аймгийн сонгуулийн хэсгийн хороодод ажиллах төрийн албан хаагчдад зориулсан ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулж байна. Сургалтад тус аймгийн сонгуулийн 99 хэсэгт ажиллах 100 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдсан.



ХЗДХЯ-амны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Энэрэлт жаргал галуу ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны Баян-Өлгий аймаг дахь салбартай хамтран "Хөгжлийн бэрхшээл ба хүртээмж" сэдвээр мэдээлэл өгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс худалдан авалт хийсэн.

Мөн насан туршийн суралцахын төвтэй хамтран Гэр бүлийн үнэ цэнэ болон гэр бүлийн хүчирхийлэл, Харилцаа ба хандлага сэдэвтэй сургалтад хамруулав. Сумдын улсын бүртгэгчид цахимаар оролцсон.



ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академийн төрийн захиргааны албан хаагчдад зориулсан ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, богино хугацааны сургалтад 2 албан хамрагдаж, амжилттай суралцаж төгссөн.

### **Ес. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/**

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай нягт хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

"Цахим засаглал" хөтөлбөр, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх ажлын хүрээнд аймаг сумдын ИТХ, Засаг дарга, удирдлага нартай хамтран ажиллаж, санал хүргүүлснээр Орон нутгийн хөгжүүлэх сангаас энэ онд

- Хэлтсийн төвд Улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 18.000.000 төгрөг, 4G зөөврийн төхөөрөмж 698,000 төгрөг
- Алтанцөгц сум Улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 23.000.000 төгрөг
- Алтай сум Улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 23.000.000 төгрөг, шилэн кабелийн медиа конвертор 300,000 төгрөг
- Сагсай сум Улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 23.000.000 төгрөг
- Цэнгэл сум ДӨТ /киоск/ машины хурууны хээ уншигч 200,000 төгрөг

- Өлгий сум ЗДТГ-аас тус аймагт зохион байгуулагдсан бүсчилсэн сургалтад 1,000,000 төгрөг
- Үйлчилгээний болон захиргааны албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах нэн шаардлагатай суурин компьютер 1ш, зөөврийн компьютер 2ш буюу 8,157,600 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлсэн.  
Нийт 97,355,600 /ерөн долоон сая гурван зуун тавин таван мянган зургаан зуун/ төгрөг орон нутгаас шийдвэрлүүлсэн.

#### 2025 оны төсөвт

- Баяннуур сум Улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 26.000.000 төгрөг
- Ногооннуур сум Улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 25.000.000 төгрөг

Нийт орон нутгийн төсөвт 51.000.000 /тавин нэгэн сая/ төгрөгийг суулгасан байна.



Засгийн газраас өрнүүлж буй "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий талаар малчдыг мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг зөвлөгөө өгөх, хоршоо бүртгүүлэх "Малчдад туслах үйлчилгээний цэг"-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 дугаар байр буюу Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байгуулагдсан. Уг цэгээс тус хэлтсээс Хуулийн этгээдийн улсын бүртгэгч хоршооны бүртгэл хөтөлж, цогц мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэн аймгийн ЗДТГ, ХХААГ, ГХБХГ-тай хамтран ажиллаж байна.



Монгол улсад захиргааны хэргийн дагансан шүүх байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс зохион байгуулсан тэмцээнд Улсын бүртгэлийн хэлтсийн баг тамирчид амжилттай оролцсон.



Олон улсын Гэр бүлийн өдөр **#ГЭР БҮЛДЭЭ-#ГЭРЭЛ** НЭМЬЕ аяны (04.18-05.18) хүрээнд тус хэлтсийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран албан хаагчдын гэр бүл, үр хүүхдүүдэд чиглэсэн сургалт, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран зохион байгуулах, хамтран ажиллах, мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулсан.



Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан.

Орон нутгийн төрийн байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд салбар дундын хууль эрх зүйд холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх үүднээс харилцан мэдээлэл солилцож, Эд хөрөнгийн хаяг, нэгж талбарын дугаарын өөрчлөлт, кадастрын зөрүү, газар өмчлөх эрхийн өмчлөх эрх дуусгавар болох, сумдын улсын бүртгэгч нар газрын даамалуудтай хамтран ажиллах, хамтарсан сургалт зохион байгуулах зэрэг бусад асуудлаар харилцан тохиролцож ажиллахаар болсон.



ХУУЛЬЧИЙН "ПРО БОНО -2024 " өдөрлөгт оролцож иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, шинээр нэвтрүүлсэн улсын бүртгэлийн 24/7 үйлчилгээг олон нийтад таниулах, зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тогмтол ярилцлага өгч, албан байгууллагуудад мэдээллийн цаг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, сумдын улсын бүртгэгч нар БИНХ-д оролцож мэдээлэл өгч ажиллав.



Аймгийн Засаг даргын Тамгын газраас “НАУРЫЗ” баярыг угтан зохион байгуулсан төрийн байгууллагуудын “Ажилтан, албан хаагчид үндэсний хувцсыг сурталчлах” уралдаан, “Наурыз”-ын баярын өдрийн парадад “Бэр буулгах” зан заншиллыг ёслол төгөлдөр үзүүлэн оролцсон.



Цагааннуур боомтын удирдлага, албан хаагчдад Улсын бүртгэлийн шинэ үйлчилгээний талаар мэдээлэл өгч, хуурамч, зөрчилтэй гадаад паспорт, иргэний бичиг баримтыг хэрхэн шалгаж танин мэдэх, үүсэж болох эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уулзалт хийж хэлэлцүүлэг зохион байгуулсан.



Аймгийн ИТХ-аас зохион явагдсан “ЦАГААН САР - ЕС ЗАНШИЛ” фото зургийн уралдаанд Улсын бүртгэгч С.Жаргалсайхан амжилттай оролцож тэргүүн байанд

шалгарч ИТХ-ын дарга Ш.Хавыл, хурлын нарийн бичгийн дарга А.Серикболат нараас шагналаа гардан авсан.



Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх" журамд заасны дагуу жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль"-ийг хийдэг уламжлалтай.

Уг сургууль гуравдугаар сарын 28-ны өдрийн 16.00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, дадлага сургуульд амжилттай оролцсон.



Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадварын сургалтыг орон даяар үе шаттай зохион байгуулсаар байна.

Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран "ЦАХИМД ЗӨВ БАЙЯ" уриатай КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН сургалтад албан хаагч нарыг хамруулсан.



Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, Анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийг тохиолдуулан залуу үеийнхэнд эх оронч сэтгэлгээг бий болгох, шударга



амьдарч, хөдөлмөрлөж, төр түмнээ эрхэмлэн дээдлэн, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготой "Монгол Улсын Иргэний Андгай Өргөх Ёслол"-ыг сумдын улсын бүртгэгч нар зохион байгуулсан.


### Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил

"Цахим засаглал" хөтөлбөр, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх ажлын хүрээнд Аймгийн ИТХ, Засаг даргад санал хүргүүлж, ОНХС хөрөнгөөр 18 сая төгрөг шийдвэрлүүлэн Тус аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Улсын бүртгэлийн ДӨТ машины 24/7 цахим үйлчилгээг нээсэн. Уг цахим машинаас иргэд өөрөө өөртөө үйлчлэн, 24 цагийн турш бүртгэлийн үйлчилгээг хурдан шуурхай авч байна. Үүнд:

- 6 төрлийн үйлчилгээ /Иргэний улсын бүртгэлийн-3, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн-3/
- 18 төрлийн лавлагаа /Иргэний улсын бүртгэлийн-12, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн-4, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн-2
- Тоон гарын үсэг шинээр авах үйлчилгээ
- Иргэний цахим үнэмлэх дахин захиалах
- Гадаад паспорт бусад үйлчилгээний төлбөр тооцоог төлөх үйлчилгээг авч байна. Өнөөдрийн байдлаар ДӨТ машинаас 6047 иргэн үйлчилгээ, лавлагаа авсан байна. Үүнээс шөнийн цагаар 4 иргэн бүртгэлийн үйлчилгээ авсан байна.




Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт "Иргэний шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээж" гэж заасны дагуу ЕГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд иргэдэд шилжилт хөдөлгөөний статистик тоон мэдээг хүргэж ажилласан.



Засгийн газраас өрнүүлж буй "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд эрх зүйн мэргэжилтэй Улаанхус, Дэлүүн, Алтанцөгц, Алтай, Цагааннуур, Буянт, Бугат, Байаннуур, Булган сум зэрэг 9 сумын улсын бүртгэгч, аймгийн төвийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Нина нарыг хоршоог улсын бүртгэлд бүртгэх чадавхжуулах сургалт зохион байгуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх, тамга тэмдэгжүүлэн сумын малчид аймгийн төвийг зорихгүйгээр тухайн сумын улсын Хоршоо бүртгүүлэх боломжоор ханган идэвх санаачлагатай ажиллаж байна.

Шинэ хоршоо Чинээлэг малчин хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд шинээр 280 хоршоо байгуулагдсан, 28 хоршоо шинэчилсэн бүртгэлд хамрагдсан. нэрийн баталгаажилт 15 буюу нийт 66 хоршоо үйл ажиллагаа эхлүүлээд байна.



Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, төвлөрийг сааруулах зорилтын хүрээнд Үндэсний энгийн цахим гадаад паспорт захиалах, хүлээн авах үйлчилгээг 2024 оны 03-р сарын 01-нээс тус аймгийн Алтай, Алтанцөгц, Буянт, Улаанхус, Цагааннуур, Толбо сумдаас үзүүлж байна. Аймгийн хэмжээнд 9207 гадаад паспорт олгосноос 1320 иргэн сумдаас үндэсний энгийн гадаад паспортаа захиалан авсан байна.



Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригт үндэсний мод тарих өдөр хэмээн 🌳🌳 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг


аймгийн хэмжээнд өрнүүлж уг зорилтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хуваарьтай газарт хэлтсийн ажилтан, албан хаагчид мод тарих ажлыг зохион байгуулсан. 84 ширхэг бургас мод тарьсан.



Тус хэлтсийн шинээр нэвтрүүлсэн 24/7 үйлчилгээ, Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг биечлэн болон цахимаар улсын бүртгэлд бүртгүүлэх заавар, Үндэсний энгийн гадаад паспортыг алслагдсан сумдаас захиалах зэрэг 3 видео контент бэлдэж, сошиал хуудсаар реалаар цацаж олон нийтэд түгээж ажилласан.



Албан хаагчдын хүүхдийг саатуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор байгууллагад Хүүхдийн ерөө гаргаж тохижуулсан.



2024 онд 16, 25, 45 насанд хүрч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдаж иргэний үнэмлэх шинээр авах, дахин авах, сольж авах, иргэний улсын бүртгэл, ад хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авахад бүртгүүлэх материалтай хялбараар QR код уншуулан авах постер бэлдэж байгууллагын сошиал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.



орчинд үндэсний бичгээр бичих хэрэглээг нэмэгдүүлж" уриа дор нэг сарын аян өрнүүлэв.




Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 84 жилийн ой, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг тохиолдуулан Төрийн үйлчилгээний 14 байгууллагын 58 албан хаагч нарын дунд танин мэдэхүйн болон Улсын бүртгэлтэй холбоотой "АХА" тэмцээн болон албан хаагчдын дунд спортын тэмцээн зохион байгуулсан.



Иргэний улсын бүртгэлийн тасаг болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагас болон хэлтсээс 5 төрлийн видео контент бүтээж цахим хуудас болон олон нийтийн сошиалаар түгээж ард иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.

- Үндэсний энгийн цахим гадаад паспорт хэрхэн захиалах вэ?
- Биеийн давцхажгүй өгөгдлийн бүртгэлд хэрхэн бүртгүүлэх вэ?
- Шинээр баригдсан байшинг эрхийн улсын бүртгэлд хэрхэн бүртгүүлэх вэ?
- "Авлигын эсрэг НЭГДБЕ" соён гэгээрүүлэх аянд нэгдэе!
- Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 84 жилийн ой, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийн мэндчилгээний шилдэг контент





Улсын бүртгэлийн хөдөлгөөнт төхөөрөмж ашиглан бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Ахмадын хорооны 12 ахмад, ШШГТ-ын хорих ангийн 6 хоригдол, хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэдэд очиж улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.



-00-